



## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

ТЭГЭВЭР	2019.11.2019	2021.10	2022.10
Сарын үндсэн зарим	778904	78821344	30158152
3 жилдний сарын тоо	1357	1357	36
3 хэлбэрийн сарын үндсэн	Г.Чингисийн дундагч		83775422
Төрийн албанд ажигласан			28483643

2022 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 5/812

Улаанбаатар хот

### Б.Нэргүйг ажлаас чөлөөлж, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 82.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1</sup>.1.7, 271<sup>1</sup>.1.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасан Гаалийн ерөнхий газрын харьяа "Чингис хаан" олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч Бүдээгийн Нэргүйг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Б.Нэргүйд төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 28483600 /хорин найман сая дөрвөн зуун наян гурван мянга зургаан зуун / төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3. Ажлаас чөлөөлөгдөж байгаа Б.Нэргүйгийн гаалийн улсын байцаагчийн хувийн дугаар бүхий тэмдэг, ялгах тэмдгийг хүлээн авах, холбогдох тооцоо зохих журмын дагуу хийхийг "Чингис хаан" олон улсын нисэх буудал дахь гаалийн газар /Г.Баасандорж/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ